



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/722  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА Т.ПҮРЭВ-ОЧИР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (4 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**  
**“ТӨМӨРБУЛАГ СУМЫН ӨРХ БҮРИЙН ТӨЛӨӨ”**

1. <u>ӨРХ-ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ</u>	1.1 Хүүхэд таны төлөө 1.2 Ахмадууд таны төлөө 1.3 Залуучууд таны төлөө
2. <u>БАГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ</u>	2.1 Малчин таны төлөө 2.2 Байгал орчин таны төлөө 2.3 Багийн асуудал бүрийн төлөө
3. <u>СУМЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ</u>	3.1 Аялал жуулчлал бидний төлөө 3.2 Дэд бүтэц-Бүтээн байгуулалт бидний төлөө 3.3 Сумын асуудал бүрийн төлөө

**1. ИРГЭН- ӨРХ БҮРИЙН ТӨЛӨӨ**

**1.1 Хүүхэд таны төлөө**

Төмөрбулаг сумын нийт хүн амын 39 хувь буюу 0-18 насны 2000 орчим хүүхэд байна.

- ✓ Төмөрбулаг сумын хүүхдийн эрх ашгийг хамгаалсан дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулна.
- ✓ Төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудын дэргэд хүүхэд хамгааллын орон тооны бус зөвлөлийг бий болгож Идэр бүсийн Хүүхэд хамгаалал хөгжлийн төвийг бий болгоно
- ✓ Жил бүрийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 30 хүртэл хувийг хүүхдэд ээлтэй бүтээн байгуулалтад зарцуулна.
- ✓ Хүүхдэд ээлтэй баг, байгууллага хөтөлбөрийг нэвтрүүлж гэмт хэрэг зөрчлийн хамтарсан гэрээ байгуулж хэрэгжүүлнэ.
- ✓ Нэгд Хүүхэд хэмээх үзэл баримтлалыг хэрэгжүүлж жишиг сум болно.
- ✓ Хүүхдийн хүмүүжил- боловсрол стандартыг дээшлүүлж, хяналтын бүрэн хэрэгжүүлнэ.

**1.2 Ахмадууд таны төлөө**

- ✓ Баг бүрд байгууллага бүрд ахмад настны зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан дэмжин ажиллана.
- ✓ Амьдрах ухааны сургалт хөтөлбөрийг сургуулийн НТБ-ын төвтэй хамтран хэрэгжүүлнэ.
- ✓ “Ахмадууд-Нэгт” сумын үйлчилгээний журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- ✓ Ахмадын Урлаг-Спортын бага наадмыг жил бүр зохион байгуулж нийгмийн идэвх оролцоог дэмжиж ажиллана.
- ✓ Ахмадууд –Амьд Архив өв соёл, түүх соёлын мэдээллийн бааз, сан хөмрөгийг бий болгож ажиллана.

**1.3 Залуучууд таны төлөө**

- ✓ Залуучуудын асуудлыг шийдэх иргэний нийгмийн байгууллагыг идэвхжүүлж үйл ажиллагааг нь чиглүүлнэ.
- ✓ Залуучуудын хувь хүний хөгжил, гэр бүл, амьдрах ухаан, хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил олгох сургалтыг зохион байгуулна.
- ✓ Засаг даргын дэргэдэх залуучуудын төрийн албанд бэлдэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



*(Handwritten signature)*

- ✓ Сумын залуучуудын санаачилга, оролцоо, хяналтад тулгуурлан хуримтлалын бүлэг байгуулах ажлыг бодлогоор дэмжиж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.
- ✓ Залуучууд ба Залгамж халаа сумын бодлогын баримт бичгийг боловсруулж төрийн байгууллага болон хувийн хэвшилд хэрэгжилтийг хангуулах
- ✓ Сумын Залуучуудын ажиллах хүчний нөөц бүрдүүлнэ.
- ✓ Залуучуудыг орон нутагтаа “Сумандаа сайхан амьдаръя” төслийг нэвтрүүлнэ.
- ✓ Залуучууд ба Хөгжил жил бүр нийгэм рүү чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.
- ✓ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлж Залуучуудтай холбоотой төсөл хөтөлбөр бүрийн орон нутагтаа нэвтрүүлнэ.

## **2. БАГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ**

### **2.1 Малчин таны төлөө**

- ✓ Баг бүрд малчдын сайн дурын үндсэн дээр бүлэг, хоршоог байгуулах өдөрлөг, арга хэмжээг жил бүр зохион байгуулна. Малчдын бүлэг, хоршоог сургалт мэдээллээр дэмжиж хуримтлалын сантай болоход нь арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- ✓ Багийн засаг даргын ивээл дор Залуу малчин Уралдаант хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлнэ.
- ✓ Малын хашаа хөтөлбөрийг хэрэгжүүлнэ .
- ✓ Сумын бэлчээр ашиглах журмыг боловсруулж хэрэгжилтийг хангуулна.
- ✓ Сарлагийн ашиг шимийг нэмэгдүүлэх, хөөвөр хэрхэн бэлтгэх сургалтыг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, бэлтгэсэн хөөврийг зах зээлийн эргэлтэд оруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилготой “Сарлаг” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Тааварлаг сүрэг ба Малчдын бүлэг байгуулж малыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг эхлүүлж Түүхий эд бэлтгэлийн анхан шатны бааз бий болгох
- ✓ Жил бүр Эрүүл малчин-Эрүүл мал эрүүл мэндийн үзлэг оношилгоог аймаг холбогдох байгууллагатай хамтран хийж ажиллана.
- ✓ Чинээлэг малчин хөтөлбөрийг орон нутагт нутагшуулж Төмөрбулаг сумын малын үүлдэр угсааг сайжруулах дэд хөтөлбөрийг батална
- ✓ Мал эмнэлгийн үйлчилгээг малчдад ойрхон хүртээмжтэй болгох асуудлыг шат шатанд шийдүүлнэ.
- ✓ Монгол улс болон ОУ-ын хэмжээнд Малчин-Мал руу чиглэсэн аливаа хөтөлбөр арга хэмжээг ямагт орон нутагтаа нутагшуулж хамтарч ажиллана.
- ✓ Зөвлөх малчин сумын дэд хөтөлбөрийг бүсийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллана.
- ✓ Отрын бүс нутгийг чөлөөлүүлэхэд анхаарч ажиллана.

### **2.2 Байгаль орчин таны төлөө**

- ✓ УТХГ-ын Орчны бүсийн үйл ажиллагааг сайжруулж ОУ-ын болон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.
- ✓ Хог хаягдлын менежментийг төлөвлөгөөг бий болгож Хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Ойн тухай хуулийг хэрэгжилт, байгалийн дагалдах баялгийг хамгаалж ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- ✓ Усны тухай хуулийн хэрэгжилт болон ус бохирдолтоос, булаг шанд ширгэхээс хамгаалсан орон нутаг руу чиглэсэн аливаа хөтөлбөр ажлыг дэмжиж ажиллана.



- ✓ Байгаль хамгаалах-ашиглахтай холбоотой төрийн бус байгууллага нөхөрлөл хоршооны үйл ажиллагааг сайжруулж хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

### 2.3 Багийн асуудал бүрийн төлөө

- ✓ Баг бүрд хадлан тэжээлийн бүлэг нөхөрлөл байгуулах
- ✓ Баг бүрийн зам засварын ажлыг жил бүр гүйцэтгэх
- ✓ Улирал бүхэн багт Төрийн үйлчилгээний Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж асуудлыг шийдвэрлэдэг болно.
- ✓ Баг бүрийн бэлчээр, хадлан, булаг шандыг хамгаалж ажиллана.
- ✓ Сумын хөгжил –Багаас эхэлнэ арга хэмжээг уламжлал болгож багийн иргэдийн нийгмийн оролцоог байнга дэмжиж ажиллана.
- ✓ Багийн хилийн цэс, бэлчээрийн нутгийн асуудлыг аймаг улсын бодлоготой уялдуулан шийднэ.
- ✓ Багийн ИНХ-ыг тогтмолжуулж багийн асуудлыг багт нь шийдэж багийн өрх бүрийн оролцоог нэмэгдүүлж багийн онцлогт тохирсон өрхийн үйлдвэрлэлийг бодлого боломжоор хангана

## 3. СУМЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ

### 3.1 Аялал жуулчлал бидний төлөө

- ✓ Төмөрбулаг сумын аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг гаргах
- ✓ Аялал жуулчлалаас сонирхсон оролцсон иргэн бүр орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- ✓ Аялал жуулчлал хариуцсан орон тооны бус зөвлөл байгуулж, улс болон аймгаас хэрэгжүүлж буй аливаа бодлого хөтөлбөртэй уялдаа холбоотой хамтран ажиллана. Аялал жуулчлал ба Оюутны амралт компани ажлыг хамтран зохион байгуулна.

### 3.2 Дэд бүтэц-Бүтээн байгуулалт бидний төлөө

- ✓ Төмөрбулаг сумын ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулна
- ✓ Малчны хороолол, үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийг тогтоож хөгжүүлнэ.
- ✓ Сумын төвийн доторх замын замын тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- ✓ Төмөрбулаг сумын хаягжуулалтын ажлыг төр хувийн хэвшлийн байгууллага, өрх айлуудыг нэг стандарт болгон Орон нутгийн төсвөөс шийднэ.
- ✓ Аймаг сум хоорондын авто замыг Хөвсгөл аймгийн автозамын мастер төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын төсвөөр шийдүүлж ажиллана.
- ✓ Төрийн байгууллагуудын шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмж тавилга эд хогшлыг улсын төсвийн болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр үе шаттай шийдвэрлэж ажиллана.
- ✓ Сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлийг хянана.

### 3.3 Сумын асуудал-Хөгжил бүрийн төлөө

- ✓ Төмөрбулаг сумыг ОУ-ын хэмжээнд сурталчлах цахим веб хаягийг бүтээх
- ✓ Хувийн хэвшлүүдийн хөгжлийн хамтын сантай болгох
- ✓ Хуулийн хэрэгжилт манай суманд жил бүр Төмөрбулаг сумын хэмжээнд нээлттэй сонсголын арга хэмжээг зохион байгуулна.
- ✓ Хотгойд өв соёлын наадмыг Төмөрбулаг сумаасаа түүчээлэн эхлүүлнэ.
- ✓ Орон нутгийн орлого орох боломж нөхцөлүүдийг хуулийн хүрээнд шийдэж ажиллана.
- ✓ Айл бүхэн, байгууллага бүрийг үүрэг хариуцлагын бүртгэлийн дэвтэртээ болгоно.

ТӨМӨРБУЛАГ СУМ АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

1720000001 1070605


3



0000000003

- ✓ Архи болон гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллах ба иргэдийн хууль эрхзүйн мэдлэгийг байнга нэмэгдүүлнэ.
- ✓ Эрүүл мэндийн салбарын эмчийг ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангана.

ТӨМӨРБУЛАГ СУМЫН ӨРХ ГЭР БҮЛИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, СУМ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛНЭ.



A handwritten signature in blue ink, appearing to be a stylized name.

0000000000